



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 01/413

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Боловсролын
хэлтсийн Эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,148,364.08 /арван хоёр сая нэг зуун дөчин найман мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг найман мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс /Ж.Байгаль/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 7 нэр төрлийн 4,271,168 /дөрвөн сая хоёр зуун далан нэгэн мянга нэг зуун жаран найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 12 нэр төрлийн 7,877,196.08 /долоон сая найман зуун далан долоон мянга нэг зуун ерэн зургаан төгрөг найман мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс /Ж.Байгаль/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/138 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

1119282495 2576589

115050001001

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын 2020 оны 07 дугаар сарын 30 өдрийн
 4/13 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс

төгрөгөөр

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэх өртөг	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ комиссын хурлын шийдвэр
Машин тоног төхөөрөмж										
1	Компьютер	9	ш	3	540,000.00	1,620,000.00	1,620,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах
2	Компьютер	9	ш	2	605,500.00	1,211,000.00	1,211,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах
3	Принтер 2010	9	ш	1	138,821.00	138,821.00	138,821.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах
4	Принтер	8	ш	1	373,953.68	373,953.68	373,953.68	-	Дахин ашиглах боломжгүй	татах
5	Принтер	8	ш	1	157,547.25	157,547.25	157,547.25	-	Дахин ашиглах боломжгүй	татах
6	Хувилагч	8	ш	1	1,167,075.00	1,167,075.00	1,167,075.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах
7	Скайнер	9	ш	1	77,718.15	77,718.15	77,718.15	-	Дахин ашиглах боломжгүй	татах
8	Тог баригч	9	ш	1	43,991.00	43,991.00	43,991.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах
9	Компьютер	9	ш	1	672,100.00	672,100.00	672,100.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах
10	Проектор	6	ш	1	609,990.00	609,990.00	609,990.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах
11	Ус буцалгагч	9	ш	1	25,000.00	25,000.00	25,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	татах

12	Неүтбүүк	9	ш	2	890,000.00	1,780,000.00	1,780,000.00		Дахин ашиглах боломжгүй	татах
Машин тоног төхөөрөмжийн дүн				16		7,877,196.08	7,877,196.08			
Тавилга, эд хогшил										
13	Жижиг тумбочка	9	ш	1	12,000.00	12,000.00	12,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Устгах
14	Сандал	9	ш	4	23,750.00	95,000.00	95,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Устгах
15	Сандал	9	ш	1	171,000.00	171,000.00	171,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Устгах
16	Сандал	9	ш	6	85,000.00	510,000.00	510,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Устгах
17	Сандал	9	ш	10	273,520.80	2,735,208.00	2,735,208.00	-	Дахин ашиглах боломжгүй	Устгах
18	Дугуй ширээ	9	ш	1	114,000.00	114,000.00	114,000.00	-	Дахин ашиглах боломжгүй	Устгах
19	Ширээ	9	ш	1	633,960.00	633,960.00	633,960.00	-	Дахин ашиглах боломжгүй	Устгах
Тавилга, эд хогшлын дүн				24		4,271,168.00	4,271,168.00	-		
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				40	12,148,364.08		12,148,364.08			
Үүнээс. Устгах хөрөнгө				7	4,271,168.00					
Татан төвлөрүүлэх хөрөнгө				12	7,877,196.08					